

The background features abstract, flowing shapes in vibrant blue and orange colors, resembling liquid or smoke, set against a plain white background. The shapes are dynamic and organic, with some appearing as large, rounded forms and others as more intricate, branching structures.

Студийн гэрэлтүүлэг

2020 он


Студийн гэрэлтүүлэг

- Телевизийн ямар ч төрлийн нэвтрүүлэг хийхэд сэдэв, зохиол, зураг авалт, эвлүүлэгтэй зэрэгцэн тайзны засал чимэглэл гэрэлтүүлгийн тавил зохиогдоно. Тайз засал чимэглэл, гэрэлтүүлэг, дуу чимээ үзэгдэлдээ нийцсэн байх ба үзэгчдэд таатай сэтгэгдэл төрүүлэхээс гадна тухайн нэвтрүүлгийн орчинг бүрдүүлж, сонирхолтой, бусдаас ялгарах өвөрмөц дүр төрхийг бүрдүүлдэг.



Студийн гэрэлтүүлэг

- Телевизийн нэвтрүүлгийн тайз засал, чимэглэл гэрэлтүүлэг нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
 1. Уран сайхны үүднээс: Нэвтрүүлгийн зорилго бүтэц хэлбэрт нь таарсан оновчтой байх.
 2. Техникийн үүднээс: Тайз засал нь студийн багтаамжид нийцсэн байх байна.
 3. Дүрс бичлэг хийх, студийн гэрэлтүүлгийн тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагаанд саад болохгүй байх.



Телевизийн студийн гэрэлтүүлэг



ХӨТЛӨГЧИЙН СТУДИ

Мэдээ, сурвалжлага
ярилцлага,
сурвалжилсан
тэмдэглэл, тойм

Ердийн гэрэлтүүлэг
тавина.



ТЕАТР - ДРАМЫН СТУДИ

Телегүүр, теле
театр

Уран сайхны
гэрэлтүүлэг тавина.



ЦЭНГЭЭНТ НЭВТРҮҮЛГИЙН СТУДИ

Найруулга, мэтгэлцээн,
уралдаант цэнгээт
нэвтрүүлэг, тоглолтын
үзүүлбэр

Уран сайхны
гэрэлтүүлэг тавина.

Студи нь дараах ерөнхий шаардлагыг хангасан байна.

1. Гадны дуу чимээнээс тусгаарлагдсан байна.
2. Хана таазыг дуу чимээ тусгаарлах материалаар доторлоно.
3. Гадагшаа харсан цонхгүй байна.
4. Хоёр давхар хаалгатай байна.
5. Шал нь тэгш гадаргуу бүхий резинэн матираалаар хучигдсан байна.
6. Студи, найруулагчийн өрөөний хоорондох цонх 2-3-н давхар шилтэй байна.
7. Дуу дүрс гэрэлтүүлгийн төхөөрөмжүүд байнга суурилсан байна.
8. Өрөөний температур 18°C – 22°C , харьцангуй чийглэг 50% – 60% байна.
9. Студийг агааржуулалтын системээр тоноглоно.
10. Дүүжин гэрлийн төхөөрөмжүүдийг шалны төвшнөөс дээш заасан өндөрт байрлуулна.

(Standdart 2: <http://www.estandart.gov.mn/>)



Телевизийн студийн гэрэлд тавих үндсэн үзүүлэлт



№	Үзүүлэлт	Том студи	Дунд студи	Бага студи	Хөтлөгчийн студи
1	Халуун гэрэл	4 – 4,5 метр			
2	Хүйтэн гэрэл	3 – 3,5 метр			
3	Студийн талбай /метр ² /	600-1500	300 - 450	100 - 150	60 -80
4	Студийн өндөр /метр /	12,5 – 19	8- 10,5	5 – 6	4, 4,5
5	Студийн урт /метр /	30 – 50	21,5 – 27,5	13 – 17,5	10,4 – 11,8
6	Студийн өргөн /метр /	20 – 30	14 -16,5	8 – 9,7	6 – 7
7	Гэрэлтүүлгийн хэмжээ /люкс /	2000	2000	2000	2000
8	Өнгийн температур /келвин /	3200	3200	3200	3200
		6500	6500	6500	6500
9	Халуун гэрлийн нэгж лампы дээд чадал /Вт/	5000	3000	2000	500
10	Хүйтэн гэрлийн нэгж лампы дээд чадал /Вт/	55	55	55	55


Гэрэлтүүлгийн стандарт тавил




№	Гэрэлтүүлгийн нэр	Тавих тавил
1	Үндсэн гэрэлтүүлэг (key)	Объектийг дээрээс нь, эсвэл эгц өмнө талаас нь нэгэн жигд гэрэлтүүлдэг.
2	Зурах гэрэлтүүлэг (Draw lighting)	Тайзан дээр болж байгаа үйл явдлын тодотгож өгөх ёстой хэсэг рүү чиглүүлсэн гэрлийн тусгал. Зурах гэрэлтүүлгийг дангаар хэрэглэх нь ховор. Учир нь объектын хэлбэрийг тодотгодог.
3	Контур гэрэлтүүлэг (back lighting)	Аливаа биетийн арын фоноос нь ялгаж өгөх зорилгоор хэрэглэдэг. Объектоос холгүй зайд, ар талаас нь тусгадаг.
4	Дэвсгэр гэрэлтүүлэг (spot lighting)	Тухайн объектын зөвхөн арын фонын хэсгийг гэрэлтүүлдэг. Дэвсгэр гэрэлтүүлэг нь ерөнхий болон зурах гэрэлтүүлгээс бүдэг байх ёстой. Тайзан дээрх үйл явдлын уур амьсгалыг илэрхийлэхэд гол төлөв ашиглана.
5	Зөөллөх гэрэлтүүлэг (soften lighting)	Хурц сүүдрийг бууруулж, уусгалт хийж өгнө. Хүйтэн болон халуун лампууд ашигласан задгай гэрлийг хэлнэ.
6	Дүүргэх гэрэлтүүлэг (Fill lighting)	Тухайн объектыг гэрэлтүүлэх үндсэн гэрлийн тусгалаар үүсэх сүүдрийг арилгах зориулалт бүхий гэрлийг хэлнэ.

Студийн гэрэлтүүлгийн стандарт тавил


1 Үндсэн гэрэл



2 Зурах гэрэл




3 Контур гэрэл




4 Дэвсгэр гэрэл



5 Зөөллөх гэрэл



6 Дүүргэх гэрэл




Студийн гэрэлтүүлэг

- Гэрэл үүсгэгчийн талбай гэрэлтэлтийн хэмжээ дүрсний чанарт их нөлөөлдөг. Дүрсний чанарыг гэрлийн талбайн хэмжээ гэрэлтүүлж байгаа зайгаар удирддаг. Гэрлийн талбай хэчнээн бага байна төдий чинээ огцом шилжилттэй сүүдэр үүсгэнэ. Гэрлийн талбай хэчнээн том байна тэдий чинээ өргөн шилжилттэй зөөлөн сүүдэр үүсгэнэ. Зарим тохиолдолд арын фоны тод бүдгээс гэрэлтүүлгийн хэмжээ хамаардаг. Цагаан фон бага гэрэл бараан фон их гэрэл шаардана.



Гэрэл тавих дараалал

- 1. Фон гэрлийг тохируулна
- 2. Үндсэн гэрлийг тохируулна /гэрэлтэлт нь фоны гэрлийн тод бүдгээс хамаарна/
- 3. Зөөллөх гэрлийг / Камерын зүгээс өгнө. Сарниулагч эсвэл гэрэл ойлгогч ашиглаж болно/
- 4. Контор гэрлийг тохируулна / хүнээс дээш 1.5-2 метр зайдтай байна. / фоксолдог гэрлүүд сайн тохирдог



Гэрэлтүүлэгчийн гэрэл

тавих аргачлал

- Телевизийн студид их гэрэл тавих нь
: Зочин болон
хөтлөгчид сандраа үүсгэж хөлс гаргах
шалтгааны нэг болдог. Үндсэн 3 гэрлийн
тавилтыг голчлон тавьдаг . Гэрлийг
тавихдаа
1/2 харьцаатай тавьдаг. Жишээ
нь: / шар , цагаан өнгийг холих, ягаан
цагаан өнгийг холих гэх мэт/




Гэрэлтүүлэгчийн гэрэл тавих аргачлал

- Халуун чиглэсэн гэрлийн лампыг хүйтэн гэрлээр сольж хийж урд нь улбар шар туяатай Фильтер хийн их чадалтай чиглэсэн гэрлээр орлуулж болно. Халуун гэрэлтэй лампанд цэнхэр Фильтер хийн хүйтэн гэрлийн өнгийг тэнцүүлнэ. Фильтер нь өтгөн, шингэн гэсэн 2 төрөл байдаг.



Гэрэлтүүлэгчийн гэрэл тавих аргачлал

- Телевизийн хана гэгээлэг байвал гэрлийн ойлт жигд тархдаг. Өтгөн шингэн өнгийн фильтрийн кодыг хаарууллаа.



Гэрэлтүүлэгчийн ажлын үүрэг




Албан ажил	Гүйцэтгэх үүрэг
Гэрлийн найруулагч	Гэрлийн найруулагч нь найруулах ур зүйн ойлголттой архитектур дизайн болон өнгөний талаар өргөн мэдлэг мэдрэмжтэй байх хэрэгтэй. Уран сайхны мэдрэмж бүтээлч санаагаар баяжуулан уран бүтээлд хувь нэмрээ оруулдаг. Уран бүтээлийн гэрлийн тоног төхөөрмжийн угсралт бэлэн болоход гэрлийн удирдлага программын хэсгийг хариуцан гэрлийн найруулагыг найруулагчтай хамт хийнэ.
Ерөнхий гэрэлтүүлэгч	Гэрэлтүүлгийн албаны цаашдын хөгжлийг тодорхойлно. Шинэ техник технологийг нэвтрүүлэх гэрээ хэлэлцээр хийнэ. Албаны ажилчдаа хариуцна. Ажлын төлөвлөгөөг боловсруулж ажлын явцыг зохион байгуулна.
Гэрлийн техникч	Нэвтрүүлгийн утга санаанд тохируулан тухайн нэгжид харьяалагдаж буй тоног төхөөрөмжийг ашиглан товолсон хугацаанд гэрэлтүүлгийн тоног төхөөрөмжийг угсарч байрлуулна.
Гэрлийн засварын инженер	Тухайн нэгжид харьяалагдаж буй тоног төхөөрөмжийн аюулгүй, бүрэн бүтэн байдлыг хариуцаж засвар үйлчилгээ явуулах үүрэгтэй.

Гэрлийг удирдаж тохируулах хэд хэдэн арга байдаг. Аливаа дүрсийг дундаж зөв дүрстэй хэсэг, сүүдэр хэсэг, хурц толбо хэсэг гэж 3 хуваадаг.


Зөв дүрстэй дундаж хэсэг

Юмсын гадаргуугийн (фактур) ширхэг бүгд тов тод гарсан хэсгийг хэлнэ. Зурах болон үндсэн гэрлийн тавилтаар зөв дүрс үүсгэдэг. Зөв дүрстэй хэсэг нь юмсийн тухай бодит ойлголт өгдөг. Жишээ нь : Төмөр яг төмөр шиг, ус яг ус шиг харагдах ёстой. Үүнд 100Вт чиглэсэн гэрлийг ашигласан байдаг.




Сүүдэр хэсэг :

Сүүдэр хэсэг зөв дүрстэй үндсэн хэсгээс ямагт бага байна. Сүүдэр хэсэг юмсийн хэлбэр дүрс орон зайн гүнийг өсгөн тодруулдаг. Сүүдэр хэсгийн их багаас дүрсний зөрүү (контраст) хувирч байдаг. Энэ зөрүү нь үндсэн гэрэл зөөллөх гэрэл хоёрын зөрүүнээс гарсан үр дүн юм. Сүүдрээс зөв дүрсрүү шилжсэн зааг хичнээн огцом нарын байна дүрс төдий чинээ ширүүн төрхтэй болдог. Хэрэв энэ шилжилтийн зааг өргөн, аажим ууссан маягтай байвал дүрс зөөлөн байдаг. Задгай эсвэл 50Вт чиглэсэн гэрэл ашигласан байдаг.



Хурц толбо: Толбо нь зөв дүрстэй үндсэн хэсгээс үлэмж их, юмсын гадаргуугийн ширхгүүд сайн ялгарахгүй зарим хэсэгтээ бүр гялайгаад ямар ч дүрсгүй болдог. Юмсын гадаргуу гялгар бол толбо гэрэл, зөв дүрс хоёрын шилжилтийн зааг их огцом байдаг. Толбыг заримдаа ойсон гэрэл ч гэж нэрлэдэг. Зөв тохируулсан толбо гэрэл юмсын хэлбэр дүрс гүний орон зайг нөгөө хоёр гэрлээсээ илүү тодруулдаг. Шил, вар, шаазан, металл, ус, тосорхог юмсийг гялгар гадаргуугаас ойн толбо гэрлийг үүсгэдэг. Ойсон гэрлийг бүдэгрүүлэхийн тулд гялгар гадаргууг грим пудр мэт бүрсгэр ширхэгтэй бодисоор өнгөлдөг. Пүшиг гэрлийг ашигласан байдаг.




Биетийн өнгө, материал дүрс бичлэгт үзүүлэх нөлөө




№	Биет	Дүрс, бичлэгт үзүүлэх нөлөө
1	Гялалзсан мөнгөлөг материал	Студийн хурц гэрэлд гялалзсан мөнгөлөг материал ойж хурц толбо үүсгэдэг.
2	Цайвар бүдэг өнгийн хувцас	Студийн хурц гэрэлд цайвар бүдэг өнгийн хувцасны харагдах байдал муу байдаг.
3	Бараан өнгийн хувцас	Биеийн галбирыг илүү тодотгож өгдөг.
4	Цайвар дэвсгэр дээрх жижиг нарийн судалтай хувцас	Хувцасны нарийн судал нь анивчиж байгаа мэт сэтгэгдэл төрүүлдэг.
5	Гялалзсан материалтай эдлэл, тэлээ, хүзүүний зүүлт, бүс товч	Студийн гэрэл сайтар тохироогүй тохиолдолд дэлгэц дээр цагаан толбо үүсгэдэг.
6	Болор шилэн эдлэл	Гэрэлтүүлгийн нөлөөнд гялбаа үүсгэдэг. Анхаарал саринуулна.
7	Царим нэг төрлийн цулгүй өнгө	Дүрсийн боловсруулалт хийх үед бодит өнгө нь алдагдана.
8	Цагаан өнгийн нимгэн цамц	Хурц гэрэлтэй нөхцөлд цагаан цамцны зарим нэг детал телевизийн дэлгэцээр гарахдаа ялгарч харагддаггүй.

Биетийн өнгө, материал дүрс бичлэгт үзүүлэх нөлөө

- Дээрх хүснэгт байгаа студийн гэрэлтүүлгийн үндсэн үзүүлэлтийг баримтлаагүйгээс сөрөг нөлөө, чанаргүй дүрс бичлэг бий болдог. Дүрс бичлэгт сөрөг нөлөө гаргахгүйн тулд гэрэлтүүлгийн үндсэн үзүүлэлтийг ханган люкс метр багажаар биетээс ойж буй гэрэлтэлтийн хэмжээг хэмжиж тохируулдаг.
- Люксметр гэдэг нь: Гэрэл үүсгэгч болон ойсон гэрлийн гэрэлтэлтийг мэдэрч хэмждэг багаж юм. (Өмнөх хичээл дээр үзсэн)



The background features vibrant, flowing liquid-like shapes in shades of blue and orange against a white background. The shapes are dynamic and organic, resembling ink or paint splatters that have been captured in motion. The blue shapes are more concentrated on the left side, while the orange shapes are more prominent on the right and top. The overall effect is one of energy and movement.

Анхаарал хандуулсанд
баярлалаа